

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
Ө ЭНХТҮВШИН

2019 оны ... дүгээр сарын ... өдөр

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДАД ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг боловсролын байгууллагын барилга, байгууламжид зохион байгуулж, болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлагийн байгууллагын галын аюулгүйн дүрэм, бусад галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2. Хяналт шалгалтад оролцох бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Их, дээд, коллеж, ерөнхий боловсролын сургууль, оюутны дотуур байр, цэцэрлэгийн барилга байгууламжуудад хяналт шалгалтыг зохион байгуулна.

2.4. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ноогдуулна.

2.5. Хяналт шалгалтыг “Боловсролын байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас” загварын дагуу зохион байгуулж, дүнг шалгасан барилга байгууламж тус бүрээр удирдамжийн 3.4-д заасан хаягаар цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.6. Удирдамж болон боловсролын байгууллагын барилга байгууламжийн гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсыг meta.gov.mn Газар хэлтэс, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналт цэснээс татаж авна.

2.7.Хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний цахим бүртгэлийн программын мэдээллийн санд нэг бүрчлэн оруулсан байна.

Гурав. Хяналт шалгалт явуулах хугацаа, зардал

3.1.Хяналт шалгалтын ажлын хэсгийг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга томилон удирдлагаар хангаж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

3.2.Томоохон их, дээд сургуулиудад хяналт шалгалтыг хийхдээ 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тушаалаар томилон ажиллуулна.

3.3.Хяналт шалгалт явуулахад шаардлагатай зардлыг тухайн орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцна.

3.4.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс 08 дугаар сарын 30-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 09 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд тус тус явуулна.

3.5.Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн, мэдээг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн Hyanaltiinheltes.obeg@yahoo.com цахим хаягаар зөрчлийг фото зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт ирүүлнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

4.1.Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын вэб хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

4.2.Онцгой байдлын ерөнхий газраас хяналт шалгалтын дүн, санал дүгнэлтийн талаарх танилцуулгыг шалгалтад хамрагдсан байгууллагуудын харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шат дараатай авч хэрэгжүүлнэ.

4.3.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын дарга, гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж, холбогдох яам, агентлаг, газрын дарга нарт гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн танилцуулга, мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР